



ШҮҮХИЙН АКАДЕМИ

**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХ ЗОРИУЛАЛТТАЙ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ДОТРООС БУСДЫН ЭД
ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛСАН НЬ НЭВТРЭХ
ШИНЖИД ХАМААРАХ ЭСЭХ” ТУХАЙ ШҮҮХИЙН
ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2025.01.15

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХ ЗОРИУЛАЛТТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ДОТРООС БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛСАН НЬ НЭВТРЭХ ШИНЖИД ХАМААРАХ ЭСЭХ” ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ¹

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн практикт хамгийн түгээмэл шийдвэрлэгддэг гэмт хэргүүдийн нэг болох хулгайлах гэмт хэрэг²-ийг шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 2024/ХШТ/119³ дугаар тогтоолыг сонгон авав. Тус шийдвэрийг шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг дэмжих, цаашид зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, төсөөтэй хэргүүдийг хянан шийдвэрлэхэд эрх зүйн тогтвортой байдлыг хангахад ач холбогдолтой гэх үндэслэлээр сонгосон болно.

Энэхүү дүн шинжилгээ нь шүүхийн шийдвэрийн танилцуулах хэсэг, шийдвэрлэсэн байдал, дүн шинжилгээ, дүгнэлт хэсгээс бүрдэнэ. Шүүхийн шийдвэрийн **танилцуулах хэсэг нь** шүүхийн шийдвэрийн дугаар, шийдвэрийн төлөв, хэргийн тухай товч гэсэн дэд хэсгүүдийг агуулах бол **шийдвэрлэсэн байдал хэсэгт** анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийг товчлон дурдав. Харин **дүн шинжилгээ хэсэгт** эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт, төсөөтэй шүүхийн шийдвэр, гадаадын зарим улсын (*ХБНГУ болон АНУ*) эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судаллаа. **Дүгнэлт хэсгээр** сонгон авсан шүүхийн шийдлийн үндэслэлд дүгнэлт өгнө.

НЭГ. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024/ХШТ/119⁴

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн.

Хэргийн тухай товч

Б.Э нь хэд хэдэн удаагийн үйлдлээр Эрүүгийн хуулийн (2015) тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт холбогджээ. Тодруулбал:

- Б.Э нь хүнсний дэлгүүрээс хохирогчийн гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 400,000 төгрөгийн хохирол учруулсан;

¹ Энэхүү дүн шинжилгээг Шүүхийн академийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Эрүүгийн эрх зүйн секторын судлаач О.Инжиннаш, Э.Баасанбямба, З.Янжинлхам, Б.Ундрам болон Э.Төгөлдөр нар хийж гүйцэтгэв.

² Жишээлбэл, 2023 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн 10.3%, 2024 оны эхний хагас жилийн байдлаар мөн ойролцоо хэмжээг хулгайлах гэмт хэрэг дангаараа бүрдүүлжээ.

ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны статистик, 2023, 2024.07 <https://www.judcouncil.mn/site/news/7> (Сүүлд үзсэн: 2024.11.23).

³ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3635?daterange=2024/01/01%20-%202024/11/12%20&id=3&court_cat=2&bb=1

⁴ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3635?daterange=2024/01/01%20-%202024/11/12%20&id=3&court_cat=2&bb=1

- Б.Э нь мөн үргэлжилсэн үйлдлээр Б.Б-тэй бүлэглэн захын хашаанаас мотоциклийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 450,000 төгрөгийн хохирол учруулсан;
- Б.Э нь Д.Ү-тэй бүлэглэн бусдын хашаанд байсан Sonata 6 маркийн тээврийн хэрэгслийн хойд талын гурвалжин шилийг хагалан обудтай дугуй, дугуйн торцов; Vodgo J2 загварын тээврийн хэрэгслийн баруун хаалганы цонхыг хагалж нэг нүдний дуранг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 310,000 төгрөгийн хохирлыг учруулсан гэх үйл баримт тогтоогджээ.

ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Прокуророос дээрх хэрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Анхан шатны шүүх⁵: Б.Э-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хулгайлах гэмт хэргийг, бусадтай хамтран, үргэлжилсэн үйлдлээр үйлдсэн гэм буруутайд тооцож 1 жилийн хорих ял, Д.Ү-г хулгайлах гэмт хэргийг хамтран гүйцэтгэгчээр үйлдсэн гэм буруутайд тооцож 6 сарын хорих ялаар шийтгэж, өмнөх шийтгэх тогтоолоос эдлээгүй үлдсэн 350 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял, мөн эдлээгүй үлдсэн 27 хоногийн хорих ялыг нэмж нэгтгэн биечлэн эдлэх ялыг 6 сар 27 хоногоор тогтоожээ.

Давж заалдах шатны шүүх⁶: “Б.Э нь урьд 7 удаагийн ял шийтгэлтэй, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт удаа дараа ял шийтгүүлж байсан, хулгайлах гэмт хэргийг үргэлжилсэн үйлдлээр 3 удаа үйлдэж, уг гэмт хэргийг үйлдэж олсон ашиг орлогыг өөрийн хэрэгцээнд зарцуулах, архи уух зэргээр бусдын өмчлөх эрхэд халдсан үйл баримт тогтоогдсон тул байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх хүндрүүлэх шинж тогтоогдсоноос” гадна “түүний таксинаас гар утас хулгайлсан үйлдлийг нэмж шалгах шаардлагатай” талаар дүгнэж шийтгэх тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүх: “Давж заалдах шатны шүүх шүүгдэгч Б.Э-ын үйлдсэн гэмт хэргийн үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийхдээ зөвхөн үйлдсэн гэмт хэргийн тоо, давтамж болон өмнөх ял шийтгэлийн байдалд тулгуурлан шүүгдэгчийг хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн” тул хэргийг ердийн бүрэлдэхүүнээр зүйлчлэн, ял шийтгэсэн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол үндэслэл бүхий болсон талаар дүгнэж магадлалыг хүчингүй болгож, шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

⁵ Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 108 дугаар шийтгэх тогтоол.

https://shuukh.mn/single_case/106806?daterange=2024-01-01%20-%202024-04-03&id=1&court_cat=2&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.12.20).

⁶ Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 37 магадлал, https://shuukh.mn/single_case/20107?daterange=2024-05-01%20-%202024-06-03&id=2&court_cat=2&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.12.20).

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүгийн хуулийн тусгай ангийн (цаашид “ЭХТА” гэх) 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэргийг хууль тогтоогч үндсэн бүрэлдэхүүн, хүндрүүлэх бүрэлдэхүүн болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилсан. Үүнээс хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох ЭХТА 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад заасан “*хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн*” шинжийн агуулгыг тодруулах зорилгоор дээрх шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэгт дүн шинжилгээ хийлээ. Өөрөөр хэлбэл, гурван шатны шүүхээс шүүгдэгч нар нь “*Sonata 6 маркийн тээврийн хэрэгслийн хойд талын гурвалжин шилийг хагалан обудтай дугуй, дугуйн торцов, Bodgo J2 загварын тээврийн хэрэгслийн баруун хаалганы цонхыг хагалж нэг нүдний дуранг тус тус хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч бусдад 310 000 төгрөгийн хохирол учруулсан*” үйлдлийг ЭХТА-ын 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ердийн бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэгт хамааруулан үзсэн нь эрүүгийн эрх зүйн онол, шүүхийн өмнөх жишигтэй хэр нийцэж байгаад дүгнэлт өгөхөд энэхүү дүн шинжилгээний зорилго оршино.

3.1. Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

Хулгайлах гэдэг нь шунахай сэдэлттэйгээр бусдын өмчийн эд хөрөнгийг хууль бусаар, нууцаар авч өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлэхийг хэлнэ. Уг гэмт хэргийн халдлагын зүйл нь бусдын өмчийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө юу ч байж болно.⁷ Монгол Улсад тодорхой орон зайд зөвшөөрөлгүй нэвтэрч бусдын эд хөрөнгийг хулгайлах явдлыг “**битүү хулгай**” хэмээн нэрлэж⁸ гэмт хэрэгт тооцож ирсэн уламжлалтай. Өмчийн эзэн өөрийн өмчлөлийн эд хөрөнгөө харж хамгаалах үүргээ зохис ёсоор биелүүлсээр байхад бусдын тусгайлан хамгаалсан эд хөрөнгөд хүрэхийн тулд хууль бус арга, зэвсэг, хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэн зүйлчилдэг. Өөрөөр хэлбэл хулгайлах гэмт хэргийг орон байр, агуулахад нэвтэрч үйлдсэн бол хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинжид хамруулдаг бөгөөд уг шинжийг 2002 оны Эрүүгийн хуульд “*орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн*” гэж, 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “*хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн...*” хэмээн тус тус хуульчилжээ.

Уг хүндрүүлэх шинжийн талаар Эрүүгийн хуулийн шинжлэх ухааны тайлбаруудад дараах нийтлэг агуулгаар тайлбарлажээ. Тухайлбал, хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн гэж бусдын эд хөрөнгийг хууль бусаар авахын тулд эзэмшигч, өмчлөгчийн орон байр, агуулахад түлхүүр тааруулах, багаж хэрэгсэл ашиглах, хаалга, цонх, түгжээг эвдэх, цуургыг сугалах, онгорхой байхад сэм орох, нуугдах зэрэг бусад аргаар нэвтрэн орсныг ойлгоно. **Орон байр, агуулах саванд нэвтрэх нь гэмт этгээдийн зорилго биш ба бусдын эд хөрөнгийг шамшигдуулах санаархлаа хэрэгжүүлэхийн тулд тухайн эд хөрөнгөд хүрэх**

⁷ Г.Совд, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, 2005, 214-215 дахь тал.

⁸ Д.Адъяабазар, *Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт*, 1998, 95 дахь тал.

боломж олж авах арга юм. Уг арга нь ил, далд түүнчлэн, хуурч мэхлэх (сантехникч, шуудах хүргэгч, байцаагчийн хуурамч үнэмлэх ашиглах зэрэг) хэлбэртэй байж болно.⁹ Харин тусгайлан хамгаалсан агуулах, сав гэдэгт эд хөрөнгийг байнгын буюу түр хадгалах байр, чингэлэг, агуулах, авто мухлаг, **авто машин**, граж, мухлаг хамаарна.¹⁰

Улсын дээд шүүхээс гаргасан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэргийн тайлбарт уг шинжийг мөн дээрхтэй төсөөтэй агуулгаар тайлбарлажээ:¹¹

Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 28 дугаар тогтоолын хэсгээс:

145.2 дахь хэсэгт заасан “**Агуулах сав**” гэдэг нь эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байшин, пин, амбаар, илүү гэр, гэрийн болон тээврийн чингэлэг, бүх төрлийн агуулах, зоорь, авто мухлаг, **хөргөх ба эд бараа зөөх төхөөрөмжтэй автомашин**, граж, албан тасалгаа, үйлдвэрлэлийн эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байр, түүнчлэн **хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан болон тусгай зориулалтын автомашины кабин**, багаж, онгоц, галт тэрэг, далайн хөлгийн ачаа хадгалах сав зэргийг хамааруулан ойлгоно.

145.2 дахь хэсгийн “**орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн**” гэдгийг түлхүүр тааруулах, багаж хэрэгсэл ашиглах буюу ашиглахгүйгээр цонх, хаалга, түгжээг эвдэх, цуургыг сугалах, онгорхой байхад нь сэм орох, нуугдах зэрэг бусад аргаар нэвтрэн орохыг ойлгоно. Мөн тодорхой хугацаанд байх эрх бүхий этгээд өөр цаг хугацаанд үйлдвэрлэлийн байр, албан тасалгаа зэрэгт зөвшөөрөлгүйгээр орсон байвал орон байр, агуулах саванд нэвтэрсэн гэж үзнэ хэмээн тайлбарлажээ.

Үүнээс үзэхэд эрүүгийн эрх зүйн онол болон практикт тусгайлан хамгаалсан агуулах, сав гэдэгт автотээврийн хэрэгслийг хамааруулан ойлгож иржээ хэмээн дүгнэж болохоор байна.

3.2. Төсөөтэй шүүхийн шийдвэр

Дүн шинжилгээний энэ хэсэгт бусдын автомашинд хууль бусаар нэвтэрч эд зүйл хулгайлсантай холбоотой төсөөтэй хэргүүдийг хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн шийдвэрүүд, тэдгээрийн үндэслэлийг тодруулан авч үзье.

Улсын дээд шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 53 дугаар тогтоол: ¹²

Хэргийн тухай товч : А нь 2023 оны 03 дугаар сарын 30-наас 31-нд шилжих шөнө байрны гадаа тавьсан тээврийн хэрэгслийн хаалганы шилийг хагалж, бүхээгт нэвтрэн гар цүнхтэй гоо сайхны хэрэгслийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 235,000 (хоёр зуун гучин таван мянга) төгрөгийн хохирол, хор уршиг учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхийн шийдвэр, үндэслэл: Прокурорын газраас дээрх үйл баримтыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-г зааснаар яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн.

Анхан шатны шүүх гэмт хэргийн шинжийн талаар “...автомашиныг тусгайлан хамгаалсан байр, агуулахад хамааруулан ойлгохгүй, улсын яллагч яллах дүгнэлтдээ хуучин хуулийн тайлбарыг

⁹ Б.Галдаа, *Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл*, 2012, 137 дахь тал.

¹⁰ С.Жанцан, *Монгол Улсын эрүүгийн эрх зүй (тусгай анги)*, 2003, 147 дахь тал.

¹¹ Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Батбаяр, М.Цэдэвсүрэн, *Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, 2011, 720-721 дэх тал.

¹² Улсын дээд шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 53 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/3319?start_date=&end_date=&id=3&court_cat=2&bb=1

ашигласан нь учир дутагдалтай...” хэмээн дүгнэж хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлэн өөрчилжээ.

Тус шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч гаргасан прокурорын эсэргүүцлийг **давж заалдах шатны шүүх** хянан хэлэлцээд “...бусдын эзэмшлийн автомашин нь тусгай цоожтой, тухайн автомашиныг эзэмших эрхгүй этгээд халдаж бүрэн бус байдлыг алдагдуулж дотор нь хадгалагдаж буй эд зүйлийг авах нь түүний өмчлөл эзэмшлийн зүйлд халдаж буй үйлдэл болохыг анхаарч үзэлгүйгээр шийдвэрлэсэн нь дутагдалтай. Шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ноцтой зөрчсөн” үндэслэлээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хүлээн авч хянан хэлэлцээд шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Ингэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д “...тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” гэж заасан нь зөвшөөрөлгүй буюу **хууль бусаар нэвтэрч, халдашгүй байдлыг зөрчиж, бусдын эд хөрөнгийг авсан байхыг гол шинжээ болгодог**. Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд **хохирогч өөрийн эд зүйлсээ түр хадгалах зориулалтаар тэдгээрийг өөрийн автомашиныхаа бүхээгт үлдээн, бусдын хууль бус халдлагаас сэргийлэн автомашиныхаа хаалгыг түгжиж, цонхыг хааж битүүмжлэн орхиж явснаас харахад тэрээр өөрийн автомашиныг тухайн үед эд зүйлээ хадгалах агуулах савны зориулалтаар түр ашигласан** гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгсэл нь хүн болон ачаа тээвэрлэх үндсэн зориулалттай боловч тэрхүү тээврийн хэрэгслийг эд зүйл хадгалах агуулах савны зориулалтаар түр ашиглаж байгаа бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан “... тусгайлан хамгаалсан ... агуулах” гэж ойлгох нь зүйтэй хэмээн дүгнэжээ.

Уг шийдвэрээс үзвэл өөрийн эд зүйлийг хадгалах зориулалтаар автомашинд үлдээж **хаалга, цонхыг хааж түгжсэн буюу битүүмжилсэн бол тухайн тээврийн хэрэгсэл тусгайлан хамгаалсан агуулахад хамаарна**. Харин эсрэгээрээ дээрх зориулалтаар хадгалахдаа тээврийн хэрэгслийг цоожлоогүй, цонхыг хаагаагүй буюу бусдын хууль бус халдлагаас хамгаалахад зохих урьдчилсан нөхцөлийг хангаагүй тохиолдолд тусгайлан хамгаалсан агуулахын шинжийг хангахгүй хэмээн шүүхээс үзжээ. Жишээлбэл, хяналтын шатны шүүхээс шүүгдэгч Ц.Л-д холбогдох хэрэгт “*хохирогч зургийн аппаратаа түр хадгалах зориулалтаар өөрийн автомашиндаа үлдээхдээ машиныхаа цонхыг онгорхой орхиж явснаар шүүгдэгчийн хувьд уг онгорхой цонхоор гараа оруулан машины хаалгыг онгойлгож, уг зургийн аппарат авсан*”¹³, мөн шүүгдэгч Г.А-д холбогдох “*хохирогч өөрийн гар утсыг автомашиндаа үлдээж, хаалгыг түгжихгүй орхиж явсныг далимдуулан автомашин дотроос гар утсыг хулгайлж авсан*”¹⁴ үйл баримттай хэргүүдийг шийдвэрлэхдээ эдгээр тохиолдлуудад түгжээгүй автомашиныг тусгайлан хамгаалсан агуулахад хамаарахгүй буюу хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хангахгүй хэмээн дүгнэж шийдвэрлэжээ.

Дээрхээс дүгнэхэд хүн өөрийн өмчлөл, эзэмшил дэх эд хөрөнгийг бусдын хууль бус халдлагаас хамгаалах зорилгоор автомашин дотроо орхиж, хаалга,

¹³ УДШ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 47 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/2948?daterange=2021-01-20%20-%202021-12-31&id=3&court_cat=2&bb=1;

¹⁴ УДШ-ийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 111 дүгээр тогтоол, https://shuukh.mn/single_case/2840?daterange=2017-07-01%20-%202024-11-15&id=3&court_cat=2&bb=1.

цонхыг түгжиж буй үйлдэл нь тухайн нөхцөл байдалд автомашиныг тусгайлан хамгаалсан агуулахын зорилгоор ашиглаж буйг илтгэнэ гэж хяналтын шатны шүүхээс үзжээ. Ийнхүү хамгаалалт, түгжээ хийх нь тухайн эд хөрөнгөд өмчлөгч, эзэмшигчийн зүгээс халдашгүй байдлыг бий болгож буйн илрэл бөгөөд үүнийг зөрчиж халдах нь хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг хангана.

3.3. Гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт

Харьцуулсан судалгааны хүрээнд эх газрын болон Англо-Саксоны эрх зүйн бүлийг төлөөлүүлэн ХБНГУ болон АНУ-ын эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судаллаа.

3.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

Тус улсад тээврийн хэрэгсэлд нэвтэрч эд юмсыг хууль бусаар авах тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан **онц ноцтой хулгайлах гэмт хэрэг** хэмээн үзэж ердийн хулгайлах гэмт хэргээс илүү хүнд ял оногдуулдаг. Тодруулбал, Эрүүгийн хуулийн (1871) тусгай ангийн 242 дугаар зүйлд заасан хулгайлах гэмт хэрэг (*гер. Diebstahl*)-ийг үйлдсэн бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэх бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 243 дугаар зүйлд заасан онц ноцтой хулгайн гэмт хэрэг (*гер. Besonders schwerer Fall des Diebstahls*) үйлдсэн тохиолдолд 3 сараас 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус заажээ. Хууль тогтоогчоос онц ноцтой хулгайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг өндөр тогтоосон нь гэмт этгээд гадны хүн орохыг хориглосон орон зайд нэвтэрч эд зүйл хулгайлснаар тухайн этгээдийн үйлдлийн нийгмийн аюулын хэр хэмжээ өндөр байгааг илэрхийлдэг хэмээн тайлбарладаг байна.

Түүнчлэн тээврийн хэрэгслийн зорчигч суух хэсэг болон тээшний хэсгээс эд зүйл хулгайлсан эсэхээс хамааруулан ялгаатай зүйлчилнэ. Хулгайлах гэмт хэргийг **тээврийн хэрэгслийн зорчигч зорчих хэсэгт** нэвтэрч үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 1-д зааснаар хаалттай орон зайд нэвтэрч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн, харин **тээврийн хэрэгслийн тээшний хэсгээс** эд зүйлийг хулгайлсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 2-т зааснаар түгжээтэй агуулахаас эд зүйл хулгайлсан хэмээн үздэг байна. Эдгээр зохицуулалтыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 1-д¹⁵ “Хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ **барилга байгууламж, үйлчилгээ болон арилжаа эрхлэн явуулах зориулалттай өрөө эсвэл хаалттай орон зайг** эвдэлж орсон, дамжиж орсон, эсхүл хуурамч түлхүүр, бусад багаж хэрэгслийг ашиглан нэвтэрч орсон, эсхүл тухайн орон зайд нуугдаж үйлдсэн” бол хулгайлах гэмт хэргийг онц ноцтойгоор үйлдсэн гэж үзэж 3 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хаалттай орон зай гэдэг нь хүн нэвтрэх боломжтой мөн зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх зорилгоор зориуд тусгайлсан хэрэгслээр хүрээлэгдсэн,

¹⁵ Strafgesetzbuch (StGB), 1871, <https://www.gesetze-im-internet.de/stgb/BJNR001270871.html#BJNR001270871BJNG000102307>, (Сүүлд үзсэн: 2024.11.19).

хөдлөх болон үл хөдлөх орон зайг хэлнэ.¹⁶ Уг орон зай нь заавал дээвэр, тааз, түгжээтэй байхыг шаардахгүй ч хүн бүр чөлөөтэй нэвтрэхийг хориглосон байдаг.¹⁷ Үүнд: дээврийн өрөө, [суудлын автомашины зоригчийн тасалгаа](#), [ачааны машин](#), [зорчигч тээвэрлэх вагон](#), [явуулын сууц](#) (*гер. Wohnmobil*), [сууцан чиргүүл](#) (*гер. Wohnwagen*), усан онгоц, малын хашаа, хороо, аялагчид хоноглох зогсоол дээр барьсан майхан зэргийг хамруулна. Хаалттай орон зай нь заавал дээвэртэй байхыг шаарддаггүй учраас хашаалсан цэцэрлэгт хүрээлэн, агуулах талбай, хувцас солих өрөөг хаалттай орон зай гэж үзнэ.¹⁸ Харин **барилга, байгууламж нь** хана болон дээврээр хүрээлэгдсэн, газартай шалаар нягт бэхлэгдсэн байдаг бөгөөд уг барилгыг хүн байнга амьдрах зориулалтаар ашигладаг байхыг шаарддаггүй.¹⁹ Үүнд: музей, гарааш, зоорь, терас зэргийг хамруулдаг. **Арилжаа эрхлэх зориулалттай орон зай** гэдэгт худалдааны төв, супермаркет зэргийг, харин үйлчилгээ эрхлэх зориулалттай орон зай гэдэгт оффис зэргийг хамруулдаг.

Уг гэмт хэргийн объектив талын үйлдэлд хаалттай орон зайг эвдэлж орсон, дамжиж орсон, хуурамч түлхүүр болон бусад багаж хэрэгсэл ашиглан нэвтэрсэн гэх үйлдлүүд байна. **Эвдэлж орсон гэдэгт** хаалттай орон зай дахь нэвтрэх саадыг арилгах зорилгоор хаалтыг хүчээр онгойлгосныг хэлнэ.²⁰ Орох хаалгыг онгойлгоход биеийн хүч гаргасан байхыг шаарддаг ба хэрэв орох хаалга онгорхой эсвэл түлхүүрийг цоожны нүхэнд зоолттой орхисон тохиолдолд эвдэлж орсон гэж үзэхгүй.²¹ **Дамжиж орсон гэдэгт** гэмт этгээд тухайн орон зайд нэвтрэхдээ орох, гарах гарцыг ашиглахгүйгээр авирах, мөлхөх зэрэг аргыг ашигласныг хэлнэ. **Хуурамч түлхүүр эсвэл бусад багаж хэрэгслийг ашиглан нэвтэрсэн гэдэгт** эд зүйл онгорхой орон зайд байгаагүй тохиолдолд уг орон зайд хуурамч түлхүүр болон онгойлгох зориулалттай бус багаж хэрэгслийг ашиглан нэвтэрсэн байхыг хэлнэ. Түлхүүр гэх ухагдахуунд механик түлхүүрээс гадна электрон түлхүүр, чиптэй картууд мөн багтдаг. Хуурамч түлхүүр ашигласан гэдэгт гэмт хэрэг үйлдэгдэх үед гэмт этгээд тухайн түлхүүрийг ашиглах эрхгүй, эсвэл ашиглахаа больсон түлхүүр хэрэглэснийг хэлдэг байна.

[Эрүүгийн хуулийн тусгай ангийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 2-д](#) “Гэмт этгээд эд зүйлийг тусгайлан хамгаалсан түгжээтэй агуулах эсвэл бусад хамгаалах хэрэгслээс хулгайлсан бол” хулгайлах гэмт хэргийг онц ноцтойгоор үйлдсэн гэж үзэж мөн 3 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эд зүйлийг тусгайлан хамгаалсан түгжээтэй агуулахаас хулгайлсан гэж үзэх урьдач нөхцөл нь хулгайд алдагдсан эд зүйл нь түгжээтэй агуулахад байх ёстой. **Түгжээтэй агуулах** гэдэгт эд зүйлийг хулгайд алдагдахаас хамгаалах болон эд зүйлийг хадгалах зориулалт бүхий орон зай, байгууламжийг хэлэх бөгөөд уг орон зайд хүн орох боломжгүй байдгаараа 1-т дурдсан хаалттай орон зайнаас

¹⁶ Schroth, Ulrich: *Strafrecht Besonderer Teil*, 5th ed, 2010, S.176.

¹⁷ Schroth, Ulrich: S 176.

¹⁸ Zieschang: *Strafrecht Allgemeiner Teil*, 2023, S.51.

¹⁹ Харин бусдын орон байранд нэвтрэн хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 244 дүгээр зүйлд тусгайлан зааснаар орон байрны хулгайн гэмт хэрэгт тооцдог байна.

²⁰ Zieschang, S.53.

²¹ Jörg Eisele, Bernd Heinrich: *Strafrecht Besonderer Teil*, 2nd edь 2024, S.307.

ялгагдана.²² Түгжээтэй агуулах гэх ойлголтод **автомашин тээшний хэсэг**, бараа хадгалах сав, мөнгөний автомат машин, сеф, тээш зэрэг багтана. Тухайн агуулахыг гадны хүн нэвтрэхээс сэргийлж түгжсэн байх ёстой ба эд зүйлийг хулгайд алдагдах эсвэл онгойлгохоос сэргийлэх зорилгоор техникийн болон бусад хэрэгслийг ашигласан бол түгжээтэй агуулах хэмээн үздэг. **Цоожинд түлхүүрийг зоолттой үлдээсэн эсвэл агуулахын хажууд түлхүүрийг нь орхисон бол үүнийг тусгайлан хамгаалсан эд зүйл гэж үзэхгүй.**²³ Харин **бусад хамгаалах хэрэгсэл гэдэгт** унадаг дугуйны гинжин цоож, дохиоллын төхөөрөмж, дугуй түгжигч, машины жолоодлогын хүрд түгжигч зэргийг хамруулахаас гадна галт тэргэнд унтаж байхдаа эд зүйлээ хулгайд алдахгүйн тулд цүнхээ хувцсандаа бэхэлсэн утас ч уг ойлголтод багтах боломжтой гэж үздэг байна.²⁴ Иймд гэмт хэрэгтэн дугуй түгжигч суурилуулсан машиныг хулгайлсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн №2-т зааснаар зүйлчилдэг байна.²⁵

Кейс №1²⁶

Г нь зогсоолд байгаа машины тээшний хэсэгт түлхүүр зоолттой байгааг мэдээд уг машины тээшийг онгойлгон үнэтэй гольфийн цохиур хулгайлжээ.

Дээрх тохиолдолд машины тээш нь хүн орох зориулалтгүй учраас Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 1-д заасан хаалттай орон зайд хамаарахгүй. Эд зүйлийг тээвэрлэх, хадгалах зориулалттай учраас Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 2 дахь хэсэгт заасан түгжээтэй агуулахад хамаарахын тулд тухайн агуулахад гаднаас зөвшөөрөлгүй нэвтрэхээс хамгаалах үүднээс цоож, бусад түгжих төхөөрөмж, эсвэл бусад хамгаалах хэрэгслээр тусгайлан хамгаалсан байх ёстой. Дээрх хэрэгсэл нь эд зүйлийг авахад саад болохгүй бол үүнийг тусгайлан хамгаалсан гэж үзэхгүй. Машины тээшний хэсгийг түгжсэн байсан. Гэвч түлхүүр нь зоолттой байснаар гэмт этгээд уг машины тээш рүү саадгүйгээр нэвтэрч гольфийн цохиурыг хулгайлан авсан байна. Иймд эд зүйлийг тусгайлан хамгаалсан түгжээтэй агуулахаас авсан гэж үзэхгүй.

ХБНГУ-д тодорхой орон зайд нэвтэрч эд хөрөнгө хулгайлах ойлголтыг харьцангуй өргөн хүрээнд хуульчлан тайлбарладаг ажээ. Тодруулбал, аливаа хаалттай орон зайд нэвтэрч бусдын эд хөрөнгийг хулгайлахад заавал хана, дээвэр, шал зэргээр битүүмжлэгдсэн орчин байхыг шаардахгүй бөгөөд дурын хүн орохоос сэргийлж хязгаарлалт татсан бол үүнийг тухайн эд хөрөнгийг хадгалах халдашгүй орчин гэж үзэж байна. Харин тухайн орон зайг тусгайлан түгжих байдлаар хамгаалалт үүсгэсэн бол “тусгайлан хамгаалсан түгжээтэй агуулах” хэмээх тусдаа шинжид хамааруулна. Гэхдээ эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч нь түлхүүрийг зоолттой үлдээсэн, ойролцоо орхисон зэрэг өөрийн анхаарал болгоомжгүй үйлдлийн улмаас тухайн хамгаалсан орон зайд бусад этгээд нэвтрэх боломжийг бүрдүүлсэн бол уг хүндрүүлэх шинжид хамаарахааргүй байхаар тайлбарлан хэрэглэж буй нь Монгол Улсын дээд шүүхийн казуаль тайлбартай төсөөтэй байна.

²²Jörg Eisele, Bernd Heinrich, S.308.

²³ Joachim Vogel, Tonio Walter, Wilhelm Schmidt, Juliane Krause: *Großkommentare der Praxis*, §§ 242-262. 12th ed, 2010. S.161.

²⁴ Joachim Vogel, S.161.

²⁵ Joachim Vogel, S.165.

²⁶ Jurafuchs, Einbruch in einen umschlossenen Raum (§ 243 Abs. 1 S. 2 Nr. 1 StGB) und subjektive und objektive Geringwertigkeit einer Sache (§ 243 II StGB), <https://www.jurafuchs.de/>

3.3.2. Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх)-д хулгайлах гэмт хэргийг (*англ. Theft*) холбооны хууль тогтоомж (*англ. federal legislation*)-д тодорхойлон тусгаагүй.²⁷ Харин муж улсуудын Эрүүгийн хуульд заасан байдаг.²⁸ Түүнчлэн хамгаалагдсан орон зайд хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн (*англ. Burglary*) тусгай төрлийг хуульчилсан боловч АНУ-ын холбооны хууль тогтоомжид тодорхойлон тусгаагүй. Гэхдээ хууль бусаар нэвтрэхтэй холбоотой тодорхой төрлийн гэмт хэргүүдийг АНУ-ын Код-ын 18 дугаар гарчгийн 103 дугаар бүлэгт хуульчилсан байна.²⁹

Холбооны мөрдөх товчооны Гэмт хэргийн нэгдсэн тайлан хөтөлбөр (*англ. The FBI's Uniform Crime Reporting Program*)-т *хамгаалагдсан орон зайд хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг (цаашид нэвтрэх гэмт хэрэг гэх) гэдэг нь* хулгайлах эсхүл бусад хүнд гэмт хэрэг үйлдэх зорилгоор байр байгууламж (*англ. Structure*)-д хууль бусаар нэвтрэхийг хэлнэ гэж тодорхойлжээ. Уг гэмт хэргийг үйлдэхэд заавал хүч хэрэглэсэн байхыг шаардахгүй ба дараах гурван үндсэн хэлбэрт хуваадаг:

- хүч хэрэглэж нэвтрэх;
- хүч хэрэглэхгүйгээр хууль бусаар нэвтрэх;
- хүч хэрэглэж нэвтрэхийг оролдох зэрэг болно.

Мөн дээрх хөтөлбөрт "байр байгууламж" гэх тодорхойлолтод орон сууц, амбаар, байнгын оршин суух зориулалтаар ашиглаж буй чиргүүлт байшин эсхүл завь, оффис, төмөр замын машин (гэхдээ автомашин биш) буюу галт тэрэгний чиргүүл, жүчээ, хөлөг онгоц (жишээ нь усан онгоц) зэргийг багтаажээ.³⁰

Тодорхой муж улсуудын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл:

Калифорни мужийн Эрүүгийн хууль (*англ. California Penal Code*)-ийн 458 дугаар зүйлд хулгайлах гэмт хэргийг, 459 дүгээр зүйлд нэвтрэх гэмт хэргийг тус тус хуульчилжээ. Эрүүгийн хуулийн 459 дүгээр зүйл заасан нэвтрэх гэмт хэргийг “аливаа нэг хаус, өрөө, орон сууц, нийтийн байр, дэлгүүр, агуулах, тээрэм, амбаар, жүчээ, майхан, хөлөг онгоц, галт тэрэгний чиргүүл, түгжээтэй ачааны чингэлэг,

²⁷ Гэсэн хэдий ч хулгайн гэмт хэрэгтэй холбоотой зарим гэмт хэргүүдийг тусгасан байдаг. Тодруулбал, АНУ-ын Код /*англ. U.S. Code*-ын 18 дугаар гарчгийн 31 дүгээр бүлгийн 655 дугаар хэсэгт хулгайлах гэмт хэргийг банкны шинжээч үйлдэх, 656 дугаар хэсэгт хулгайлах гэмт хэргийг банкны ажилтан үйлдэх, 664 дүгээр хэсэгт ажлын тэтгэмжийн сангаас хулгайлах гэх зэрэг гэмт хэргүүдийг тодорхойлсон байдаг.

²⁸ Viktor Shestak and Dmitriy Silkin, “Consolidated theft in the U.S. criminal law. Law and the modern economy: new challenges and prospects: III conference with international participation”, *Saint Petersburg: Saint Petersburg State University of Economics*, (9 April 2020), <https://ssrn.com/abstract=3583571> (Сүүлд үзсэн: 2024-11-21).

²⁹ Тодруулбал, тус бүлгийн 2115 дугаар хэсэгт АНУ-ын шуудангийн газарт хулгайлах гэмт хэрэг үйлдэх зорилгоор хүч хэрэглэн нэвтэрч орох; 2116 дугаар хэсэгт шуудан зөөх галт тэрэг эсхүл хөлөг онгоц руу хүч хэрэглэн нэвтэрч орох; 2117 дугаар хэсэгт муж улс хоорондын эсхүл олон улс хоорондын тээвэрлэлтийн байгууламж, галт тэрэг, хөлөг онгоц, нисэх онгоц зэрэг рүү хулгайлах гэмт хэрэг үйлдэх зорилгоор нэвтэрч орох; 2118 дугаар хэсэгт Мансууруулах бодистой тэмцэх газар /*англ. Drug Enforcement Administration*-ын эзэмшил, хяналтад байх аливаа бодисыг хулгайлах, хүч хэрэглэн авах, тийнхүү зорилгоор харьяалагдах байгууламжид нэвтэрч орох гэмт хэргүүдийг тодорхойлон заасан байна. United States Code, Title 18, Chapter 103, Section 2115 – 2118.

³⁰ U.S. Department of Justice – Federal Bureau of Investigation, “Burglary”, *Uniform Crime Report: Crime in the United States, 2019, (2020)*, https://ucr.fbi.gov/crime-in-the-u.s/2019/crime-in-the-u.s.-2019/topic-pages/burglary.pdf?fbclid=IwY2xjawGrrTZleHRuA2FibQIxMAABHWM0bVu6FXZIA_iZ5T_tZJ5j-QVXAhv9CW65jMyc2TLZk10Fi-rl6N6NQ_aem_PCMA6qVeD17DxaiNhYKa8A (Сүүлд үзсэн: 2024-11-21).

чиргүүлт байшин, **хаалга нь түгжигдсэн автомашин**, нисэх онгоц, уурхай руу хулгайлах гэмт хэрэг эсхүл бусад хүнд гэмт хэрэг үйлдэх зорилгоор тэдгээр орон зайд нэвтэрч орохыг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

Нэвтрэх гэмт хэргийг дотор нь нэгдүгээр зэрэглэл болон хоёрдугаар зэрэглэл хэмээн хоёр ангилдаг. Тодруулбал, хүн **амьдрах зориулалтаар ашиглаж буй** орон байр, хөлөг онгоц, чиргүүлт байшин руу нэвтэрч орохыг уг гэмт хэргийн нэгдүгээр зэрэглэл (*англ. burglary of the first degree*) хэмээн үзэж **бусад** тохиолдлыг уг гэмт хэргийн хоёрдугаар зэрэглэл (*англ. burglary of the second degree*) хэмээн Эрүүгийн хуулийн 460 дугаар зүйлд хуульчилсан байна. Ялын хэмжээ нь нэгдүгээр зэрэглэлд 2, 4 эсхүл 6 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулдаг бол хоёрдугаар зэрэглэлд 1 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.³¹

Автомашины хаалга түгжээтэй байсан эсэх нь тодорхой нэг тохиолдлыг хулгайлах гэмт хэрэг эсхүл нэвтрэх гэмт хэргийн аль нэгээр зүйлчлэхэд чухал ач холбогдолтой. **Жишээлбэл:** 1966 онд шийдэгдсэн *Иргэд э. Масси /People v. Massie/* хэрэгт ачааны машины хаалгыг металл хавчаараар бэхэлсэн бөгөөд хаалгыг онгойлгохын тулд бэхэлгээг эвдэх шаардлагатай бол түгжигдсэн автомашин хэмээн үзэж нэвтрэлт хэмээн шийдсэн. 1971 онд шийдэгдсэн *Иргэд э. Блалок /People v. Blalock/* хэрэгт хаалга нь түгжээтэй байсан эсэхээс үл хамаарч түгжээтэй байсан тээш рүү хүч хэрэглэн онгойлгосныг нэвтрэх хэмээн шийдсэн бол 1975 онд *Иргэд э. Малколм /People v. Malcolm/* хэрэгт түгжээ нь эвдэрсэн цонхны салхивчийг нээж, улмаар түгжигдсэн байсан хаалганы түгжээг тайлсан тохиолдлыг нэвтрэлт хэмээн шийджээ. Харин 1980 онд шийдэгдсэн *Иргэд э. Вудс /People v. Woods/* хэрэгт автомашины хаалга түгжигдсэн хэдий ч цонх нь 5.5 инч хэмжээтэй онгорхой байсан хэсгээр орж доторх эд зүйлсийг хулгайлсныг нэвтрэлтэд тооцохгүй; 1988 онд шийдэгдсэн *ре Ламонт P. /re Lamont R/* хэрэгт чиргүүлт байшингийн хаалганы өмнө гинж өлгөж хашсаныг хаалга түгжигдсэнд тооцохгүй учир нь аливаа хүч хэрэглэлгүйгээр зөвхөн өлгөсөн гинжийг авах төдийд хаалгыг нээн орох боломжтой хэмээн шийдсэн ба 2001 онд шийдэгдсэн *Иргэд э. Аллен /People v. Allen/* хэрэгт түгжигдээгүй байсан автомашины зорчигчийн хаалгыг онгойлгож арын тээшийг нээсэн тохиолдлыг нэвтрэх гэмт хэрэг гэж үзэхгүй хэмээн шийдвэрлэж байжээ.³²

Үүнээс харахад Калифорни мужид түгжээтэй автомашинд нэвтэрч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 459 дүгээр хэсэгт зааснаар нэвтрэх гэмт хэрэгт, харин автомашины хаалга нь түгжигдээгүй байх тохиолдолд хулгайлах гэмт хэрэгт гэм буруутайд тус тус тооцдог байна.

Гэхдээ АНУ-ын зарим муж улсуудын эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийг автомашинд нэвтрэх үйлдсэн тохиолдолд тухайн автомашины хаалга түгжигдсэн эсэхээс үл хамааран хулгайлах гэмт хэрэгт хамааруулж үздэг байна. Тухайлбал, Пенсильвани мужид “автомашинаас хулгайлах” (*англ. theft from a motor vehicle*) гэсэн тусдаа бие даасан заалт нь хулгайлах гэмт хэргийн ерөнхий бүлэгт багтсан байдаг. Гэвч автомашин түгжигдсэн эсэхийг үл дурдсан бөгөөд аль ч тохиолдолд уг заалтын тодорхойлолтод хамаардаг байна. Тодруулбал, “аливаа этгээд бусдын хөдлөх эд хөрөнгийг тээврийн хэрэгслээс хууль бусаар авсан, авахыг завдсан, авч

³¹ California Penal Code (1872), Title 13, Chapter 2, 459-461.

³² In re James B., E031974 (4th Cir. 2003).

явсан, хууль бусаар хяналт эзэмшилдээ байлгасан бол автомашинаас хулгайлах гэмт хэрэг үйлдсэнд тооцно” хэмээн заасан байдаг.³³

Дээрх гэмт хэргийн хохирлын хэмжээ нь \$50 ам.доллараос бага үнийн дүнтэй бол хөнгөн гэмт хэргийн гуравдугаар зэрэг (*англ. misdemeanor of the third degree*) хэмээн дүгнэж \$250 ам.доллараос \$5,000 ам.доллар хүртэл мөнгөн торгуул мөн 90 хоног хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хэрэв хохирлын хэмжээ нь \$50 ам.доллараос \$200 ам.долларын хооронд бол хөнгөн гэмт хэргийн хоёрдугаар зэрэг (*англ. misdemeanor of the second degree*) хэмээн дүгнэж \$500 ам.доллараос \$5,000 ам.доллар хүртэл мөнгөн торгуул мөн 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хэрэв хохирлын хэмжээ нь \$200 ам.доллараос дээш бол хөнгөн гэмт хэргийн нэгдүгээр зэрэг (*англ. misdemeanor of the first degree*) хэмээн дүгнэж \$1,500 ам.доллараос \$10,000 ам.доллар хүртэл мөнгөн торгуул мөн 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн заасан байдаг. Харин уг гэмт хэргийг 5 жилийн хугацаанд 3 болон түүнээс дээш тоогоор давтан үйлдсэн бол хохирлын хэмжээнээс үл хамааран хүнд гэмт хэргийн гуравдугаар зэрэг (*англ. third-degree felony*) хэмээн дүгнэж \$2,500 ам.доллараос \$15,000 ам.доллар хүртэл мөнгөн торгуул мөн 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж тус тус тодорхойлжээ.³⁴

Тэгвэл Техас мужийн эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн бүлэгт автомашинаас хулгайлах тухай онцгойлон дурдаагүй хэдий ч “автомашинд нэвтрэх” (*англ. burglary of vehicles*) гэсэн тусдаа бие даасан заалт нь нэвтрэх гэмт хэргийн ерөнхий бүлэгт багтсан байдаг. Үүнд автомашин түгжигдсэн болон түгжигдээгүй аль аль тохиолдлыг хамруулдаг. Тодруулбал, Техасын Эрүүгийн хуулийн 7 дугаар гарчгийн 30 дугаар бүлгийн 30.4 дүгээр хэсэгт “аливаа хүнд гэмт хэрэг эсхүл хулгайлах гэмт хэрэг үйлдэх зорилгоор эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр автомашин эсхүл автомашины аль нэг хэсэгт хүч хэрэглэн нэвтэрч орсон тохиолдолд уг гэмт хэргийг үйлдсэнд тооцно” хэмээн заасан байдаг. Энэхүү гэмт хэргийг А зэрэглэлийн хөнгөн гэмт хэрэг (*англ. Class A misdemeanor*) хэмээн ангилж, 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж, \$4,000 ам.доллар хүртэл мөнгөн торгуулиар торгохоор хуульчилсан.³⁵

Дээрхээс дүгнэхэд АНУ-д автомашинаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг болон нэвтрэх гэмт хэргийг холбооны хэмжээнд хуульчилж тогтоогоогүй хэдий ч муж улсууд өөрсдийн хууль тогтоомждоо өөр өөрөөр тодорхойлон заасан байна. Зарим мужууд автомашинд нэвтэрч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдлыг автомашины хаалга түгжигдсэн эсэхээс хамаарч ангилал, зүйлчлэл болон ял шийтгэл нь өөр байхаар тайлбарлаж буй нь ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалттай төсөөтэй. Харин зарим мужууд автомашины хаалга түгжигдсэн эсэхээс үл хамаарч нэвтэрч орсонд тооцож, хулгайлах гэмт хэргээс илүү хүндээр зүйлчилж, ялладаг байна.

³³ Pennsylvania Statutes Title 18 Pa.C.S.A. Crimes and Offenses § 3934. Theft from a motor vehicle.

³⁴ Ibid.

³⁵ Texas Penal Code, Title 7, Chapter 30, Section 30.04. Burglary of Vehicles.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Гэмт этгээд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт санаагаа хэрэгжүүлэхдээ хаалттай орон зайд нэвтрэх зэргээр учирсан саадыг арилгах идэвхтэй үйл ажиллагаа явуулсан нь тухайн гэмт этгээдийн нийгэмд аюултай зан төлөвийн илрэл юм. Энэ тохиолдолд хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцож илүү хүнд ял шийтгэдэг. 2015 оны Эрүүгийн хуульд уг хүндрүүлэх шинжийг “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” хэмээн хуульчилсан нь 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулахад илүү нарийвчлан хуульчилжээ.

Эрүүгийн эрх зүйн онол, шүүхийн практикт ийнхүү өмчлөгч, эзэмшигчийн зүгээс хязгаарлалт, хамгаалалт тогтоосон орон зай болох агуулахад нэвтэрч бусдын эд зүйлийг хулгайлсан гэх шинжид автомашиныг хамааруулан ойлгож хэвшжээ. Тухайлбал, УДШ-ээс 2006 онд гаргасан ЭХТА (2002)-ийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай 28 дугаар тогтоолд “агуулах сав” гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан болон тусгай зориулалтын автомашины кабин, багаж зэргийг хамааруулан тайлбарласан. Энэхүү тогтоолын агуулга өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй болох нь эрүүгийн хуулийн шинжлэх ухааны тайлбаруудад адил агуулгаар тайлбарлан тодорхойлсоор байгаагаас харагдаж байна.

Гадаадын бусад улс оронд автомашинаас эд зүйлийг хууль бусаар авсныг хэрхэн зүйлчилж байгааг судлахад дараах ялгаатай байдал ажиглагдав. ХБНГУ-д автомашины тээшний хэсэг нь эд хөрөнгийг хадгалах зориулалттай бөгөөд тээшийг түгжсэн тохиолдолд түгжээтэй агуулахад нэвтэрсэн гэж үзэж ердийн хулгайлах гэмт хэргээс илүү хүнд ял шийтгэл оногдуулдаг байна. Харин зорчигч суух хэсгийг агуулах гэсэн ойлголтод хамруулдаггүй ба хаалттай орон зай гэх ухагдахуунд хамруулдаг байна. Үүнээс үзвэл ХБНГУ-д автомашиныг хүн суух зориулалттай хэсэг болон эд зүйл хадгалах зориулалттай гэсэн хэсгүүдэд хуваан ялгамжтай зохицуулдаг. Харин Монгол Улсад автомашиныг түгжсэн бол бүхэлд нь эд хөрөнгийг түр хадгалах зориулалттай тусгайлан хамгаалсан агуулахад хамааруулна хэмээн УДШ-ийн казуаль тайлбаруудад дурджээ. АНУ-ын хувьд зарим мужид тухайлбал, Калифорни мужийн Эрүүгийн хуульд хаалгыг нь түгжсэн автомашинд нэвтэрч бусдын эд хөрөнгийг хууль бусаар авсан бол нэвтрэх гэмт хэрэг, харин түгжээгүй автомашинаас эд зүйл хулгайлсан бол хулгайлах гэмт хэрэг хэмээн гэмт хэргийн тусгай төрлүүдийг хуульчилснаас үзвэл автомашины хаалга түгжээтэй байсан эсэх нь тодорхой нэг тохиолдлыг хулгайлах гэмт хэрэг эсхүл нэвтрэх гэмт хэргийн аль нэгээр зүйлчлэхэд ач холбогдолтой байна. Гэхдээ АНУ-ын зарим муж улсуудын эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийг автомашинд нэвтэрч үйлдсэн тохиолдолд тухайн автомашины хаалга түгжигдсэн эсэхээс үл хамааран хулгайлах гэмт хэрэг байхаар хуульчилжээ.

Дүн шинжилгээний хүрээнд сонгон авсан УДШ-ийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 2024/ХШТ/119 дугаар тогтоолд хэд хэдэн удаагийн үйлдлээр автомашины цонхны шилийг хагалан бусдын эд хөрөнгийг хулгайлсан шүүгдэгч нарын гэмт үйлдэл тус бүрийн шинжийг харгалзан үзэхгүйгээр нэгтгэн ЭХТА (2015)-ийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хулгайлах гэмт хэргийн ердийн бүрэлдэхүүнээр зүйлчлэн шийдвэрлэсэн доод шатны шүүхийн шийдвэрийг хэвээр

үлдээжээ. Ингэснээр хяналтын шатны шүүхээс төсөөтэй хэргүүдийг шийдвэрлэсэн өмнөх шийдвэрүүдтэй агуулгын хувьд ялгаатай шийдэл болсон гэж дүгнэхээр байна.

Тусгайлан хамгаалсан агуулахад нэвтэрч хулгайлах гэмт хэргийг үйлдсэн гэх шинжийг хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан явдал нь өөрийн өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд дурын этгээд хүрэхэд хязгаарлалт тавьсан өмчлөгч, эзэмшигчийн эрхийг хамгаалахад ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, тодорхой орон зайг тусгайлан хамгаалж түгжих хэрэгсэл ашиглан түгжиж битүүмжилсэн бол бусад этгээд хүрэх бололцоог улам бүр хязгаарлан, хадгалсан эд хөрөнгөд хамгаалалт үүсгэж, халдашгүй байдлыг бий болгодог. Энэ нь эрүүгийн эрх зүйн онол хийгээд бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтад ч нэгэн адил тусгагдсан ойлголт бөгөөд Монгол Улсын дээд шүүхээс төсөөтэй маргаануудыг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэлд ч мөн үүнтэй ижил агуулгыг тусгажээ. Иймд хуулийг тайлбарлан хэрэглэхэд тогтвортой байдлыг бүрдүүлэх нь иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, ял шийтгэлийг шударгаар оногдуулах эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад чухал юм.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээр:

Эрх зүйн эх сурвалж:

1. Эрүүгийн хууль, 2002 он.
2. Эрүүгийн хууль, 2015 он.
3. ХБНГУ-ын Эрүүгийн хууль (Strafgesetzbuch (StGB), 1871.
4. АНУ-ын Калифорни мужийн Эрүүгийн хууль (California Penal Code), 1872.
5. АНУ-ын Пенсилвань мужийн Эрүүгийн хууль (Pennsylvania Consolidated Statutes), 1929.
6. АНУ-ын Техас мужийн Эрүүгийн хууль (Texas Penal Code), 1973.
7. АНУ-ын Холбооны Код (United States Code), 1926.
8. Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 28 дугаар тогтоол.
9. Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 108 дугаар шийтгэх тогтоол.
10. Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 37 дугаар магадлал.
11. УДШ-ийн 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 53 дугаар тогтоол.
12. УДШ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 47 дугаар тогтоол.
13. УДШ-ийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 111 дүгээр тогтоол.
14. In re James B., E031974 (4th Cir. 6/12/2003).

Ном, сурах бичиг

1. Г.Совд, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, 2005;
2. Д.Адъяабазар, *Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт*, 1998;
3. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Батбаяр, М.Цэдэвсүрэн, *Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, 2011;
4. С.Жанцан, *Монгол Улсын эрүүгийн эрх зүй (тусгай анги)*, 2003.

Статистик мэдээлэл

1. ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны статистик, 2023 он, 2024 оны 07 дугаар сар - <https://www.judcouncil.mn/site/news/7>

Гадаад хэл дээр:

Англи хэл дээр

1. Viktor Shestak and Dmitriy Silkin, “Consolidated theft in the U.S. criminal law. Law and the modern economy: new challenges and prospects: III conference with international participation”, *Saint Petersburg: Saint Petersburg State University of Economics*, 2020;

2. U.S. Department of Justice – Federal Bureau of Investigation, “Uniform Crime Report: Crime in the United States, 2018”, 2019;
3. U.S. Department of Justice – Federal Bureau of Investigation, “Uniform Crime Report: Crime in the United States, 2019”, 2020.

Герман хэл дээр

1. Jörg Eisele, Bernd Heinrich: Strafrecht Besonderer Teil, 2nd ed, 2024;
2. Schroth, Ulrich, Strafrecht Besonderer Teil, 5th ed, 2010;
3. Joachim Vogel, Tonio Walter, Wilhelm Schmidt, Juliane Krause: Großkommentare der Praxis, §§ 242-262. 12th ed, 2010;
4. Zieschang: Strafrecht Allgemeiner Teil, 2023.

---o0o---